

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дашцэрэнгийн Төмөртогоо	Дугаар	L113
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Галшир сум
Төрсөн газар	Галшир сум	Төрсөн он	луу жилтэй
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Улаан шарын хурал	Сүм хийдийн дугаар	ХЭГЛ 051
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 20	Ярилцлага авсан хүн	Ч.Хулан



Хэнтий аймгийн Галшар сумын Улаан шарын хурал

-Манай судалгааны ажил 2007 онд Хэнтий аймгаар явж хуучны сүм хийдийн тухай настай хүмүүстэй уулзаж мэдээлэл цуглуулж бүх сумаар орсон. Танай нутаг оронд байсан сүм хийдээс лавлаж асуух зүйл байна? Галшар сумд хэдэн хийд байсан юм бэ?

Нэлээн хэдэн хийд байсан.

-Ямар ямар хийд байсан бэ? Артын мэргэн бандидын хийд гэж байсан уу?

Байсан. Одоо суурин дээр нь суварга босгочихсон байгаа. Мэргэн бандид гэдэг чинь хэд хэд хувилсан хувилгаан хүн байсан юм. Бариа тавиа эхлэхэд гадагшаа гарч оргоод сүүлд орж ирж баригдаад ял эдэлж байгаад Хэнтийд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

настай хүн суллагдаад ирж байсан юм. Тэгээд бие барахад нь суваргалсан нь тэр хийдийн туурин дээр байгаа суварга чинь тэр шүү дээ.

-Хамгийн том, гол хийд нь Галшарын хийд буюу Хужиртын хийд үү?

Тийм ээ.

Тэнд Наваандагва гуай, Ишдоо гуай сууж байсан юм байна лээ?

Тийм ээ. Зүүн Ганжуур гэж байсан. Дайчин Ганжуур гэж байсан. Отог болгон л хурал үүсгэж байсан.

-Хүрэн сүм гэж ямар сүм бэ?

Өвгөн ноён Пүрэвжавын шүтээний сүм байсан.

-Хүрэн сүм чинь хатных нь сүм биш юм уу?

Үгүй ээ, ноёны өөрийнх нь шүтээний сүм. Энэ нь Их Магнайд байдаг байсан. Харин хатных нь сүм бага Магнайд байдаг байсан.

-Хоёр сүм хоорондоо зайтай юу? Бүр тус тусдаа хийд байсан уу?

Зайтай. Тус тусдаа хийд байсан.

-Улаан шарын хурал гэж байсан байна?

Тийм ээ. Энэ чинь Буянт булгаараа нэрлэгдсэн байсан юм. Жодын хурал байсан юм.

-Галшарт хэдэн жодын хурал байсан бэ?

Хоёр байсан. Нэг нь хадан дотор. Бударын чулуун дунд байсан Жодын хурал.

-Та аль хуралд нь хурж байсан бэ?

Би улаан шарын хуралд.

-Та хэдэн наснаасаа эхэлж зодын ном үзэж эхэлсэн бэ?

16 наснаас. Байнга суудаггүй. Ирэн очин байдаг байсан.

-Улаан шарын хурал гэдэг маань ямархуу хурлын газар байсан тухай?

Ганц дугантай. Эрэгтэй, эмэгтэй холилдсон 30 гаруй ламтай. Мөнхийн хуралдаа цөөн ламтай хавар, зун, намар, өвлийн хуралдаа нэлээд хэдэн хүнтэй, Дэндэв гэдэг лам санаачлан байгуулсан тэргүүн нь байсан тийм хурлын газар байсан.

-Та яагаад зоч болсон юм бэ?

Манайд нэг хүн байсан юм. өнчин. Тэр хүн Мэргэн бандид Данзанямын дэргэд байсан. Тэгээд Хүүхэн хутагтад бараа болж очсон. Тэр эмэгтэй намайг чи зоч болооч гэж хэлсэн.

-Аав ээж чинь юу гэж хүлээж авсан бэ?

Тэг тэг л гэсэн. Би эхээс зургуулаа. Хоёр нь багадаа эндчихсэн. Доод талын эмэгтэй дүү ээж аавтай гэртээ байсан. Би тусдаа байсан. Нэг гавжтай хамт байсан юм. Миний нөхөр болох хүн. Баригдаад эргэж ирээгүй.

-Тэгээд зоч болъё гэхэд шүүд л авах уу? Шалгалт шүүлэг гэж байх уу?

Шүүд л авна. Энийг авна, тэрийг авахгүй гэж байхгүй. Шалгалт байхгүй.

-Багшид яаж шавь орох вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Яах юу байхав дээ. Эхлээд гандан, дамар яаж барих тухай заана. Нэг багшид тэгж шавь орно. Дараа нь тэгээд ном ном тус тусдаа багштай.

-Таны багшийг хэн гэдэг хүн байв?

Миний багш Говийн багш гэж байсан. Говийн багшийн дамжлагаар жүд авсан. Хүүхэн хутагт ч гэсэн Говийн багшийн шавь байсан. Хүүхэн хутагт жил бүр багшдаа очиж золгоно гээд явдаг байсан. Явахдаа дов сондуул ихтэй болохоор тэргээр биш дамнуургаар явдаг байсан.

-Та яагаад Говийн багшид шавь орсон юм бэ?

Нутаг ойр. Хамарын хийд чинь манай эндээс Хүүхэн хутагтад очихоос ойр шүү дээ.

-Та сууж байхдаа ямар ямар ном үзэж байсан бэ?

Ямар номсоод байх юу байхав дээ. Гэртээ долоо хоног ном үзсэн. Хээр долоо хоног явсан тэгээд л тэр шүү дээ.

-Таны авсан жүдийн дамжлага чинь ямар дамжлага вэ?

Ханд Гайжингийн дамжлага гэж.

-Ер нь зоч гэдэг чинь ямар учиртай хүн юм бэ?

Яахав. Амьтны тусыг хийе. Өвчтэй хүнийг эдгээе, Олон амьтны сүнсийг амарлуулъя гэж л зорино.

-Зоч хүн ямар ямар тангарагтай байдаг вэ?

Тангараг гэж юу байхав дээ. Амьтны тусыг хийе, өвчтэй хүний дэргэд нь очиж номоо уншиж туслая, олон амьтны сүнсийг яснаас салгая гэсэн л тангаргатай даа.

-Жорж хийнэ гэдэг нь ямар учиртай үйл вэ?

108 булаг, 108 уул, 108 булш, 108 бүүцыг 108 хоног дамжин явж номоо уншдаг юм.

-Яагаад заавал ингэдэг юм бэ?

Олон амьтны сүнсийг яснаас салгаж байгаа юм.

-Та жорз хийсэн үү?

Би тийм юманд хүрээгүй ээ. Эхэндээ ч жорзонд 108 хоног явдаг байсан. Сүүлдээ 54 хоног болсон шүү дээ. Товчлоод.

-Тэгж зорж хийж явахдаа зоч хүн ямар хоол унд идэж уудаг байсан бол?

Үгүй яахав хоол ундныхаа юмыг авч яваад жодгорынхоо хажууд хийгээд л хадгална. Хоол ундаа хийж иднэ. Тэгдэг л байсан.

-Танд сонин содон явдал тохиолдож байв уу?

Болоогүй ээ. Би чинь жорз энэ тэр хийгээгүй юм чинь.

-Ер нь энгийн хүнд бол хээр ганцаар явахад айна. Зоч хүнд энэ нь энгийн зүйл болчихдог байсан байна. Ямар учиртай юм бол?

Айхаа байчихдаг юм аа. Гандан дамраа эргүүлээд гарахаар айдаггүй юм. Номын хүч юм.

-Ер нь тэр үед зоч нар ямархуу нэр хүндтэй байсан бэ? Лам нартай адил хэмжээнд хүндлэгдэж чаддаг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өө. Их хүндлэнэ. Айлаар явж их ном уншина. Ламтай адил л үздэг байсан.

-Та 1937 оноос хойш ямар ямар ажил төрөл эрхэлж байв?

Гар үйлдвэрт ажиллаж байсан. Саальчин, малчин байсан.

-Хийдээ тарснаас хойш хурал номынхоо зан үйлийг үргэлжлүүлж байсан уу?

Ил бол чадахгүй. Ганц нэг өнгөрсөн хүний газар дээр нь бол биш, гэр оронд нь үр хүүхэд нь аваачаад ном уншуулвал очиж уншиж өгдөг л байсан.

-1990 он гарснаас хойш хурал номд хурж эхлэв үү?

Яахав мэддэг ном бол дагаад уншчихна. Мэдэхгүй бол дуугай сууж байна. Заримдаа хүний тоо гээд сууж л байдаг юм. Энд ч тэнд ч (Улаанбаатарт ч, Хэнтийд ч) дамжлага өөр байдаг юм аа.

-Та шавьтай болсон уу?

Би чинь хүнд дамжлага өгч чадахүй ш тээ. Гэхдээ ганц нэг ном заалгасан шавь хүмүүс бий.

-Одоо Монгол оронд шашин хэрхэн хөгжиж байна?

Энэ шашин чинь одоо тарнийн ёс нь их дэлгэрч байна. Энэ хөлгөн судруудыг чинь дандаа товчлоод товчлоод. Тарниар нь уншиж байгаа штээ. Тэгээд энэ хоёр хослосон хоёр урсгалын чинь гэгээ нь цацарна биз дээ наашаа. Тийм урилга байдаг юм. Уншдаг. Энэ шажныг наашаа татаж ирүүлж аль гэж. Тийм ном байдаг юм. Тийм номыг уншаад Монгол энэ хоёрыг цацруулж аль ээ гэж тэгж уншдаг юм. Манайхны тийм ном байдаг юм. Доо ёсондоо биш, агь ёсондоо л явж байгаа даа. Агийн шажин гэдэг үүсээд тэгээд л ингээд байгаа юм даа.

-Одоо ер нь жинхэнэ зоч гэж байгаа болов уу?

Ээ, мэдэхгүй. Байхгүй байх аа. Гэхдээ яаж мэдэхэв байдаг л байлгүй дээ.

Одооны зоч нар дээр үеийнх шиг хээр хөдөө яваад байхгүй байх. Явлаа гэхэд хэцүү болсон. Өөр шашны хүмүүс таараад та нар ингэж явах учиргүй гээд амь насанд нь аюултай юм болвол яана?

-Тэгээд явъя гээд зорилоо гэхэд номыг нь заадаг, дамжлагыг нь өгдөг багш байхгүй бол тэр хүн явж чадах уу? Чадахгүй л дээ.

-Танд өөр нэмж хэлэх сонирхуулах зүйл байвал яриач сонин байх болно?

Одоо ч юу байхав дээ.

-За танд баярлалаа. Лавлаж асуух зүйл гарвал дараа дахин уулзаж асуувал болох уу?

Болно оо.